

2021.03.22

Хараат

Сумын засаг даргын Тамгын газрын зүгээс ард иргэдэд төрийн үйлчилгээг зохих хууль дүрмийн дагуу үзүүлж ирлээ. ЗДТГ-ын аппарат 7 хоног бүрийн 1 дэх өдрүүдэд шуурхай цуглааныг хийж өнгөрсөн 7 хоногт хийгдсэн ажлын биелэлт, гарч буй 7 хоногт хийгдэх ажлуудын талаар мэдээллийг хэлэлцэж ирлээ. Мөн албан байгууллагын дарга, эрхлэгч нарын хурлыг 7 хоног бүрийн 5 дах өдөр хийж байгууллага дээрээ хийсэн ажлын биелэлт, дараа 7 хоногт хийх ажлын талаар мэдээллийг хэлэлцэж байна.

### **ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:**

Гамшигт нэрвэгдсэн иргэд, малчдад шатахууны дэмжлэг үзүүлэхээр ИТХ, ЗДТГ-ын хамт олон 750000 төгрөгийг сумын Онцгой комисст хандивлалаа.

Засаг даргын Тамгын газрын зүгээс малчдадаа туслах хандивын аян зохион байгууллаа.



## **Малчдадаа туслах хандивын аян**

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газраас санаачлан байгалийн гамшигт нэрвэгдсэн нутгийнхаа малчдад туслах хандивын аяныг 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна. Иргэдээс цугласан Хандив болон зарцуулалтыг олон нийтэд ил тод мэдээлэх болно.

**Тус аянд нутгийн уугуул, суугуул иргэдийг нэгдэхийг УРИАЛЖ байна.**

**ХАНДИВЫН ДАНС:**  
Хаан банк: 5463062102  
Хүлээн авагч: Н.Батгэрэл  
Холбоо барих утас: 86080694, 88086095, 86018618

Хандивлагч иргэн гүйлгээний утга дээр овог нэр, холбогдох дугаараа бичнэ үү.

**Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газар**

**НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:** Байгууллагын дарга нарын хурал болон сумын онцгой комиссын хуралд сууж хурлын тэмдэглэлийг тогтмол хөтөлж байна. Шуурхай штабын жижүүрийн үүргийг гүйцэтгэсэн. Нийгмийн ажилтны системийн сургалтанд хамрагдсан. Төрийн албан хаагчийн шалгалтаа амжилттай өгсөн. “Хүүхдийн аюулгүй байдал”, “Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аянуудын хүрээнд төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж гүйцэтгэн тайланг хугацаанд нь явуулсан.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ХҮРЭЭНД:**

**4-Р БАГИЙН ХҮРЭЭНД:**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХҮРЭЭНД:**

**МАЛ ЭМНЭЛГИЙН ХҮРЭЭНД:** Хээлтүүлгийн мэдээ, хорогдсон малын мэдээнүүдийг аймагт өгч, хяналтын постонд ажиллаж байна.

**САНХҮҮ АЛБАНЫ ХҮРЭЭНД:**

**1-Р БАГИЙН ХҮРЭЭНД:** 2020 оны баримт бичгүүдийг архивлав. Аймгийн Засаг даргын 01 албан даалгаврын хэрэгжилтийг гаргаж явуулсан. Монголын Улаан загалмайн тусламжинд 5 өрхийг хамруулан тусламжийн зүйлсийг нь гардуулсан. ХШҮнэлгээний шалгалтанд бэлтгэж шалгуулсан. Засгийн газраас зудтай сумдын малчдад олгож байгаа хүчит тэжээлийн талаарх мэдээллийг малчдад хүргэж ажилласан.

Мөн шуурхай штабын жижүүрийг үүргийг гүйцэтгэж жижүүрүүдэд хяналтыг тавьж ажиллалаа. ГХУСЗөвлөлтэй хамтран хийх ажлын саналыг хүргүүлсэн. Сумын Засаг даргын зөвлөлийн хурал, Хүүхэд хамгаалалын хамтран багийн хурлуудад суусан. Аймгийн Онцгой байдлын газрын цахим хурал Аймгийн тамгын газраас явуулсан цахим хурлуудад суулаа. Сумын Онцгой комиссын 2 дугаар хуралдаанд суусан.

Том малын хорогдлын мэдээг малчдаас авч Ц.Ундрахбаярт хүргүүлсэн. СӨГ-ын мэдээг хугацаанд нь гаргаж өгсөн. Малчны тамгагүй байсан 3 өрхийг малчны тамгатай болгов.

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭНД:** Иргэний үнэмлэхний сунгалт 5, иргэний үнэмлэх олголт 2, зөрчлийн тухай хуулийн дагуу 2 иргэнийг шийтгэлийн хуудас ногдуулж ажиллалаа.

**АРХИВЫН ХҮРЭЭНД:** ӨГСХүсэлтийн мэдээг 14 хоногт мэдээ, сарын ажлын мэдээг албан байгууллага, албан хаагч нараас авч нэгтгэн аймагт хугацаанд нь өгч байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагаж гарсан журам, дүрмийг сурталчлан таниулах аяны удирдамжийн дагуу ажил зохион байгуулахаар ажлын төлөвлөгөө, удирдамж гарган ажиллаж байна. Шуурхай штабын жижүүрийг хийж гүйцэтгэж байна.

**СУМ ОРНЫ ХҮРЭЭНД:**

3-р сарын 14-нд болсон байгалын гамшигт үзэгдлийн улмаас малаа уруудуулсан болон гэр нь нурсан айл өрхүүдээр очих, малын ялгаа хумианд очиж туслахаар 3-р сарын 16, 17-ны өдрүүдэд 5 ажлын хэсгийн 37 албан хаагч 17 газар болсон 185 өрхийн 33500 малын ялгаан дээр очиж ажиллалаа.

3-р сарын 18-ны өдрийн 12 цагт СОК-ын 6-р хуралдааныг зохион байгуулж 3 сарын 18, 19-ний өдөр сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоож малчдад туслах арга хэмжээнд нийт төрийн албан хаагчид, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг дайчлан ажиллуулахаар 4 багт 40 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй 8 техник хэрэгслийг дайчлан гаргаад байна.

Мөн төвийн хэсгийг хариуцаж мэдээ судалгааг түргэн шуурхай гаргаж холбогдох газар хүргүүлж ажиллах 4 албан хаагчийг томилж Хяналтын пост, шуурхай штабт ажиллах 10 албан хаагчийн томилгоог тодотголоо.

Малаа уруудуулсан МАЛЧИН өрх тус бүр 30000 төгрөгийн шатахууны тусламж үзүүлэхээр шийдвэрлэж 210 өрхийн нэрсийн жагсаалтыг Хөрс ШТС-д хүргүүллээ.

Сумын Онцгой комисст ИТХ, ЗДТГ-ын хамт олон 750000, цэцэрлэгийн хамт олон 480000 төгрөгийн шатахууны дэмжлэг үзүүллээ. ЕБС, Соёлын төвийн хамт олон малын ялгаан дээр байгаа албан хаагчид, малчдад халуун цай, хүнсээр үйлчиллээ.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР